



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 2/112

Амардалай

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дах заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дах заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх заалт, 38.4 дэх заалтууд болон газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэрцогт сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэр (Хадан хошуу-1 111 тоот)-д байршилтай Элбэгсанчир ХХК (4246446)-ын 1768 м.кв (0.17 га) гэр орон сууц, хашааны зориулалттай газрыг Элбэгсанчир ХХК-ийн захирал О.Хүүхэнбаатар (3E75112012)-д өмнөх газрын зориулалт, хугацаагаар үргэлжлүүлэн 14 жилээр эзэмшүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/42 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгон газрын ашиглалтад хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Д.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

4. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүй зориулалтын дагуу эзэмшихийг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

